

ДАЛД СУРВАЛЖЛАГЫГ ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭХ АРГА ЗҮЙН АСУУДАЛД

Урьхан*

* ӨМИС-ийн МСДС-ийн Сонин мэдээллийн салбарын аспирант

Түлхүүр үг: далд сурвалжлага, “халуун цэгээс хийсэн ярилцлага”, зохистой арга зам, хууль цаазыг журамлах зарчим, идэвхтэй мэдээлэл.

Сүүлийн хорин жилд БНХАУ-ын олон арван хэвлэл мэдээллийн хэрэгсэл тодорхой хэмжээгээр далд сурвалжлагыг хэрэглэх болжээ. Онцлон тэмдэглэж хэлэхэд 1994 онд Төвийн телевиз хороо далд сурвалжлагын аргаар Хэбэй мужид худал хуурмаг бараа бүтээгдэхүүн хийж арилжаалж байсан хууль бус ажиллагааг илчлэн мэдээлснээс хойш орон даяар далд сурвалжлагыг хэрэглэх арга өргөн дэлгэрсэн байна. Ингээд төвийн телевиз хорооны “Халуун цэгээс хийсэн ярилцлага” зэрэг үр нөлөөтэй хөтөлбөрөөс санаа авч, жижиг сонин хүртэл цөм далд сурвалжлагыг ямар нэг төвшинд хэрэглэх болж, далд сурвалжлага нь урьд гараагүйгээр олны анхаарлыг татаж, олон арван асуудлыг үүсгэсэн юм.

Сонин мэдээний сурвалжлагад олон янзын арга хэлбэрийг түгээмэл ашигладаг онцлогтой. Үүнд сурвалжлагчийн өөрийн “сурвалжлагч” гэдгээ далдлах эсэхээр нь ил, далд сурвалжлага гэж хоёр хуваадаг.

Ил сурвалжлага нь сэтгүүлч сурвалжлагын зохих үүргээ биелүүлж, сурвалжлагын зорилт ба сурвалжлагч гэдгээ ил тод мэдүүлэхийг хэлдэг байна. Энэ бол сэтгүүлчийн үргэлж хэрэглэдэг хамгийн энгийн сурвалжлах арга мөн.

Далд сурвалжлага гэдэг нь ил сурвалжлагатай харьцуулж хэлсэн үг юм. Одоо хэдийгээр далд сурвалжлагын тухай тогтоосон нэгдмэл ойлголт байхгүй боловч ерөнхийдөө “сурвалжлагчийн бүрмөсөн мэдэхгүй байдал доор, хулгайчаар сүүдэрлэх, дүрс шингээх, дуу шингээх зэрэг аргаар буюу сурвалжлагч гэдгээ далдлан биеэрээ оролцох аргаар, эсвэл бусад аргаар нэгэнт үүссэн буюу яг үүсч байгаа боловч хараахан илчлэгдээгүй сонин мэдээний бор

материалыг олох сурвалжлагын арга¹ хэмээн ойлгож болно.

Далд сурвалжлагын дээрх тодорхойлолтод тулгуурлан түүний доорх гурван гол онцлогийг ажиглаж болно.

1. *Сурвалжлагч гэдгээ нуух онцлог.* Сурвалжлага хийх явцад сурвалжлагч гэдгээ бусдаас нууж, өвчтөн, аянчин, арилжаачин зэрэг худал дүрээр үйл явдалд оролцож үнэн байдлыг ойлгох.

2. *Сурвалжлагч зорилгоо нуух онцлог.* Өөрийн зорилгоо бусдад мэдэгдэхгүй байдлаар сурвалжлага хийх.

3. *Материал цуглуулах арга барилаа нуух.* Сурвалжлага хийх явцад нөгөө этгээдэд үл мэдэгдэх нууц мэдээ материал цуглуулах тусгай техник хэрэгсэл ашиглах.

Гэхдээ далд сурвалжлага заавал дээрх гурван онцлогийг агуулах алба биш, харин зөвхөн аль нэг онцлог нь байвал далд сурвалжлагад багтах юм. Тухайлбал, сурвалжлагч гэдгээ далдалсан боловч сурвалжлагын зорилт ба материал цуглуулах арга барилаа нуугаагүй байж болно.

Далд сурвалжлагын үүсэл, хөгжлийн асуудалд. Далд сурвалжлага хэзээ, яагаад үүссэн, ийм арга барилыг сонгох болсон талаар хараахан нэгдмэл ойлголт байхгүй боловч дараах саналыг сонин мэдээллийнхэн үндсэндээ хүлээн зөвшөөрдөг байна. “Дэлхийн нэгдүгээр дайны дараа бүлэг тагнуулчид ажлаасаа халагдаж, ажилгүй үед нь Европ, Америк зэрэг зарим улсын мэдээллийн хэрэгслүүд эдгээр хүмүүсийг сайн таньж мэдээд, тэднийг хөлслөн, тагнуулын ажлын онцлогийг ашиглан сонин мэдээний бор материал цуглуулж эхэлсэн

бөгөөд үүний улмаас далд сурвалжлага хэмээх онцгой арга бий болжээ”² гэж үздэг байна. Дэлхий дээр хамгийн эрт далд сурвалжлагыг хэрэглэсэн хүн бол Английн “Пэлл мэлл” сонины сурвалжлагч У.Т. Сид болно. Гэвч дэлхийгээрээ түүний энэхүү хэрэглэлтийг далд сурвалжлагын соёолол хэмээн үзэж, жинхэнэ далд сурвалжлагын анхны жишээ бол харин 1890 оны Америкийн эмэгтэй сурвалжлагч Нелли Блайн “Солио өвчтөний эмнэлэг дэх арван өдөр” хэмээх мэдээллийн сурвалжлага мөн хэмээн тооцдог байна³.

Хятадын хувьд далд сурвалжлага нь XX зууны эхээр гадаадаас орж ирсэн түүхтэй юм. 1903 онд Чинжин хэмээх сурвалжлагч Чин улсын Засгийн ордон Орост улсаа худалдсан тэгш бус гэрээ тогтоох гэж байгааг тагнаж мэдээд сониндоо нийтэлсэн нь Хятадын түүхэн дэх далд сурвалжлагын анхны жишээ болсон байна. Үүнээс хойш Шо Пио Пин, Фан Чан Жиан зэрэг нэрт сурвалжлагчид далд сурвалжлагыг зохих хэмжээгээр хэрэглэж байсан юм. Шо Пио Пиний 1923 онд хэвлэгдсэн, Хятадын анхны сонин мэдээ сурвалжлага зүйн ном болох “Хэрэглээний сонин мэдээлэл зүй”-д сонин мэдээ сурвалжлагын ил ба далд төрлийн тухай дурдсан байдаг⁴. Шинэ дундад улс байгуулагдсаны дараа янз бүрийн шалтгаанаас болж далд сурвалжлага мартагдсан байдалд орж, сүүлд өөрчлөлт шинэчлэл эхэлснээс хойш л сая дахин сэргэж эхэлсэн юм. Тэгээд сонин мэдээний өрсөлдөх чадвар нь дээшилж, яриа хэлэлцээний хяналтын чангарахыг дагалдан алхам алхмаар хөгжих хандлага ажиглагдаж байна.

Далд сурвалжлагын өнөөгийн байдал. Төвийн телевиз хороо 1994 онд далд сурвалжлагын аргаар Хэбэй мужийн худал хуурмаг бараа бүтээгдэхүүн хийж арилжаалдаг тосгоныг илчлэн мэдээлээд амжилт олсноос хойш далд сурвалжлага улам эрчимтэй нэвтэрч эхэлсэн юм. Төвийн телевиз хорооны "Халуун цэг ярилцлага"-аас гадна "Сонин мэдээний байцаалт", "Сонин мэдээ 30 минут", "Аж ахуй хагас цаг" зэрэг чухал нэвтрүүлгүүд ч тодорхой хэмжээгээр далд сурвалжлагыг хэрэглэх болсон бөгөөд бусад хот, мужийн телевизүүд ч энэ аргыг хэрэглэх талаар идэвх санаачилгатай ажиллаж байна гэж хэлж болно. Жишээлбэл: Шанхайн телевиз хорооны "Сонин мэдээ үзэгдэл", Жансуугийн телевиз хорооны "Бодит дүрслэл", Хэбэй телевиз хорооны "Сонин мэдээний дэлгэр хараа" зэрэг нэвтрүүлэгт ч далд сурвалжлагын аргыг ажиглаж болно. Тэр ч байтугай зарим зугаа цэнгээний хөтөлбөрөөс ч далд сурвалжлагын шинжийг төвөггүй харж болох юм. Зарим шалгалтын дүнг үндэслэвэл, одооны төвийн телевиз хорооны далд сурвалжлагыг хэрэглэх хэмжээ нь нэгэнт 5,1%-ийг давсан байна⁵.

Үүнээс гадна "Өмнөдийн гаригийн сүүлчийн сонин", "Жин бо сонин", "Яан чива хотын оройн сонин" зэрэг сониноос

манай "Өвөр Монголын өдрийн сонин" (хятад хэл дээр), "Умардын шинэ сонин", "Хөх хотын оройн сонин", "Өвөр Монголын өглөөний сонин" зэрэг сонин далд сурвалжлагыг тодорхой хэмжээгээр ашиглах болсон байна. Эдгээр мэдээллийн хэрэгслүүдтэй адилтгавал, манай монгол мэдээллийн хэрэгслийн далд сурвалжлагыг ашиглаж байгаа байдал нь хангалтгүй, монгол радио телевиз,

монгол сонин сэтгүүлд монгол сурвалжлагчийн өөрөө далд сурвалжлага хийхээр дамжуулж мэдээлсэн идэвхтэй мэдээлэл туйлын ховор байна.

"Өвөр Монголын өдрийн сонин"-ы монгол хэвлэлээр жишээлж үзвэл 2005 оны 11-р сараас 2007 оны 4-р сар хүртэлх 546 дугаарын нийт

материалын зөвхөн 6 хувийг далд сурвалжлагын мэдээлэл эзэлж, үүний 2 хувь нь өөр сониноос авсан мэдээлэл, 2 хувь нь гэрэл зургийн мэдээлэл (хулгайгаар татсан гэрэл зураг буюу папарацци), дөнгөж 2 хувь нь сая сурвалжлагчийн биеэрээ оролцсон далд сурвалжлагын мэдээлэл байлаа.

Үүнээс бид далд сурвалжлагын хэрэглэлтийн доорх хоёр талын хандлагыг олж харж болно. Нэг нь далд сурвалжлагыг дур зоргоороо хэрэглэх хандлага юм. Үүнд далд сурвалжлагыг зүй ёсоор хэрэглэхгүй, дур зоргоороо хэрэглэх, эсвэл хэрэглэхээргүй газар ч хэрэглэх

«

Хятадын хувьд далд сурвалжлага нь XX зууны эхээр гадаадаас орж ирсэн түүхтэй юм. 1903 онд Чинжсин хэмээх сурвалжлагч Чин улсын Засгийн ордон Орост улсаа худалдсан тэгш бус гэрээ тогтоох гэж байгааг тагнаж мэдээд сониндоо нийтэлсэн нь Хятадын түүхэн дэх далд сурвалжлагын анхны жишээ болсон байна.

»

зэрэг асуудал байна. Жишээлбэл, Хуна-
ны телевиз хорооны нэгэн зугаа цэнгээ-
ний шинжтэй нэвтрүүлэг нь далд
сурвалжлагын аргыг зүй бусаар хэрэглэ-
сэн байна. Олон мэдээллийн хэрэгсэл
далд сурвалжлагыг дураараа хэрэглэс-
нээс болж хууль зөрчсөн буюу заргад
унасан явдал ч бий. Хоёр дахь хандлага
нь далд сурвалжлагаас хэт их болгоомж-
лох явдал юм. Үүнд манай монгол
мэдээллийн хэрэгсэл тэргүүтэй нэг хэсэг
мэдээллийн хэрэгсэл багтана. Эдгээр
мэдээллийн хэрэгсэл нь далд сурвалж-
лагын “онцгой” ба “асуудал дагуулдаг”-
аас нь хэт их болгоомжилж, түүнийг
гажуудуулснаас болж олон үнэ цэнэтэй
мэдээний бор материалаа алддаг байна.

Иймэрхүү далд сурвалжлагыг
туйлшран хэрэглэх хандлагын
аль нь ч өрөөсгөл зүйл юм. Далд
сурвалжлага нь ил сурвалжлагаар олж
чадахааргүй сонин мэдээний бор
материал хийгээд сонин мэдээний үнэн
мөнийг олж дийлдэг боловч зарим онц-
гой чанартай байдгаараа тэр нь зөвхөн
ил сурвалжлагын нөхвөр сурвалжлага л
байх ёстой. Гэвч зарим хүн зөвхөн
түүний “асуудал”-ыг нь олж харахад,
зарим нь зөвхөн түүний үйлдлийг нь олж
харснаас болж хэрэглэлтийн ийм ханд-
лагыг буй болгосон байна.

*Далд сурвалжлагыг зохистой хэрэг-
лэх арга зам.* Далд сурвалжлагын хувьд
одоо болтол хууль эрх зүйн тодорхой
орчин бий болоогүй учир тэр нь
хараахан албан ёсны сурвалжлага болж
чадаагүй юм. Гэвч далд сурвалжлага нь
яриа хэлэлцээний хяналт тавих хамгийн
чухал арга барил, ил сурвалжлагын
чухал нөхвөр сурвалжлага бөгөөд өдий

төдий нийгмийн дутагдал доголдлыг
илчлэн мэдээлж чаддагаараа зарим
онцгой тохиолдолд хэрэглэхгүй байхын
аргагүй сурвалжлагын арга болжээ.
Гэсэн ч бид далд сурвалжлагыг дураа-
раа хамаагүй хэрэглэж болохгүй, эрхбиш
урьдач нөхцөлтэй, зарчим ёсоор зүй
зохистойгоор хэрэглэж далд сурвалж-
лагыг улам хууль ёсны болгох хэрэгтэй
юм.

Урьдач нөхцөл. Далд сурвалжлагад
өдий төдий дутагдал ба хүрэлцэхгүй тал
оршиж байгаа учраас энгийн сурвалж-
лага байцаалтын аргаар хэрэг учрын
үнэн мөнийг мэдээлж тайлдаг л юм бол
далд сурвалжлагыг хэрэглэхгүй байвал
зохино. Яах аргагүй байдалд далд
сурвалжлагыг заавал хэрэглэх шаардла-
гатай болсон үед сая хичээсэн дээрээ
хичээж, нямбайлсан дээрээ нямбайлж
хэрэглэх хэрэгтэй. Тэгвэл ямар байдалд
сая далд сурвалжлагыг хэрэглэх вэ?

1. Сурвалжлуудагч этгээд нь нэгэнт
зохих хэмжээний гэрч баримтаар олон
нийтийн ашиг тусад халдсан үйл ажил-
лагаатай хэмээн гэрчлэгдсэн үед үүнд
сурвалжлагдахаар байгаа ажиллагаа нь
нийтийн ашиг тусад халдсан байхыг
чухалчилна. Далд сурвалжлага нь олон
нийтийн ашиг тусын шаардлагыг тэргүүн
зэрэгт тавих хэрэгтэй. Жишээлбэл,
эмнэлгийн хороо худал эм худалдаж
байх, сүүний үйлдвэр сүүндээ хольц
нэмсэн, үхсэн гахайн мах арилжаалж
байх зэрэг нь цөм олон нийтийн ашиг
тусад халдаж байгаа хэрэг болно.

2. Энгийн арга барилаар дамжин гэрч
материал цуглуулж дийлэхгүй үед хэрэг-
лэнэ. Даруй сурвалжлагын явцад хулгай-
чаар сүүдэрлэх, дүрс шингээх, дуу

шингээх зэрэг аргаас өөр ямар ч аргаар мэдээллийн гэрч материалыг цуглуулж дийлэхгүй үед хэрэглэнэ.

3. Ил сурвалжлагаар хэргийн үнэн мөнийг ойлгож дийлэхгүй үед хэрэглэнэ. Өөрийгөө сурвалжлагч гэдгээ ил болгосон үед хэрэг учрын үнэн байдал, сурвалжлуулагчийн үнэн дүр төрх болон харанхуй үйл ажиллагааг нь илчилж чадахгүй үед хэрэглэнэ.

4. Холбогдох байгууллагын зөвшөөрлийг авах хэрэгтэй. Энэ нь сурвалжлагчдалд сурвалжлага хийхдээ дээд шатны удирдах байгууллагад мэдээлж, тэдний зөвшөөрлийг авах шаардлагатай гэдгийг бодож, дураараа хандахгүй байхыг санах хэрэгтэй юм.

5. Хууль зөрчихгүй байх хэрэгтэй. Далд сурвалжлага нь хууль эрхийн тогтоосон хүрээнд хийгдэж, дараах зүйлийг юуны өмнө анхаарах хэрэгтэй. (1) Далд сурвалжлага нь улсын нууцыг хамгаалах дүрэм тогтоолыг бат журамлах хэрэгтэй. Хятадын 1988 онд баталсан "Улсын нууцыг хамгаалах хууль"-ийн 20 дугаар заалтад: "Сонин сэтгүүл, ном судар, газрын зураг, зураг эвхмэл, дуу дүрс шингээлтийн зүйлийн хэвлэн тархалт ба программ, телевиз, кино зэргийг үйлдэх ба нэвтрүүлэх явц нь цөм хамаа бүхий нууцыг хамгаалах дүрэм тогтоолыг журамлаж, улсын нууцыг задруулахгүй байх хэрэгтэй" гэж тогтоосон байна. 1983 онд бас "Радио телевизийн нууцыг хамгаалах түр хэрэглэх дүрэм" тогтоож, 1992 онд Улсын нууцыг хамгаалах товчоо, Төвийн гадагш ухуулах бага дугуйлан, Сонин мэдээ хэвлэлийн яамны хамтаар "Сонин мэдээ хэвлэлийн нууцыг хамгаалах

тогтоол"-ыг баталж, 1995 онд Улсын нууцыг хамгаалах товчооноос бас "Шинжлэх ухаан техник мэргэжлийн нууцыг хамгаалах хууль" хийгээд "Дундад улсын чөлөөлөх цэргийн нууцыг хамгаалах дүрэм"-ийг тогтоож, улсын нууц хийгээд цэргийн явдлын нууц зэрэг нууцуудыг цөм мэдээлж нэвтрүүлж болохгүй гэж тогтоосон байна. (2) Насанд үл хүрэгсдийг хамгаалах хамаа бүхий дүрмийг бат журамлах хэрэгтэй. Хятадын "Насанд үл хүрэгсдийг хамгаалах хууль"-ийн 30 дугаар заалт "Ямарваа зохион байгуулалт хийгээд хувь хүн ч гэсэн цөм насанд үл хүрэгсдийн хувийн нууцыг илчилж болохгүй" гэж тогтоосон бөгөөд 42 дугаар заалт: "Насанд үл хүрэгсдийн ял хийсэн үйл ажиллагаанд хамаг эцсийн шүүн таслалт өгөхөөс өмнө ямар ч радио, телевиз, сонин сэтгүүл зэрэг мэдээллийн хэрэгсэл нь тус насанд үл хүрэгсдийн нэр, орон сууц, сүүдэр зэрэг материал хийгээд үүнээс ондоо тус насанд үл хүрэгсдийн бие гэгийг илрүүлж мэдэх ямарваа материалыг цөм илчлэн мэдээлж болохгүй" гэж тогтоосон байна.

Үүнээс гадна "Эрүүгийн заргын хууль" хийгээд "Насанд үл хүрэгсдийн ял хийхээс сэргийлэх хууль"-д цөм насанд үл хүрэгсдийн ял хийсэн үйл ажиллагааг илээр шүүн тасалж болохгүй гэж тогтоосон байдаг. (3) Хууль цаазын хамгааллыг хүртэж байгаа аж ахуйн нууцад халдаж болохгүй. Аж ахуйн нууц гэдэг бол тэдний түргэн хөгжлийг дагалдан буй болсон нэгэн шинэ ухагдахуун юм. Хятадын "Тэгш бус өрсөлдөөнийг эсэргүүцэх хууль"-д нэгэнт энэ хамаатай

дүрэм тогтоолыг тогтоосон байж, 1995 онд улсын Аж үйлдвэр худалдааны товчоо ч тус тогтоолыг үндэслэн "Нууцыг халдсан үйл ажиллагааг хориглох тухай тогтоол" гаргаж, үүнд "Зүй зохисгүй арга барилаар бусдын аж ахуйн нууцыг олох, хэрэглэх, эсвэл илчлэхийг цөм аж ахуйн нууцад халдсан үйл ажиллагаагаар үзнэ" гэж тогтоосон байна.

Далд сурвалжлагын хамрах хүрээ. Далд сурвалжлага хийх талбайн сонголт: зээл дээр, зугаа цэнгэлийн газар зэрэг олон нийтийн талбарт далд сурвалжлага хийж болно. Хувийн орон сууц зэрэг хувь хүний орон зайд далд сурвалжлага хийж болохгүй.

Далд сурвалжлагын сурвалжлагчийн "дүр" сонголт: далд сурвалжлагад сурвалжлагч ямагт өөрийн жинхэнэ нэр дүрээ нуун далдалж, өөр ямар нэгэн худал "дүр"-ээр сурвалжлага хийдэг байна. Сурвалжлагч иймэрхүү худал "дүр" сонгохдоо нийгмийн аливаа дүрийг сонгож болно. (1) Сурвалжлагч далд сурвалжлага хийхдээ улсын албан байгууллагын ажилтан, хууль цаазын ажилтан, улсын ажилтан зэрэг дүрээр ажиллаж болохгүй. (2) Сурвалжлагч хууль зөрчигчдийн дүрээр ажиллаж болохгүй. Энэ нь сурвалжлагч зохих зорилгодоо хүрэхийн төлөө ял хийхээс сэргийлсэн явдал юм. (3) Сурвалжлагч өөр хүйсийн хүний дүрээр далд сурвалжлага хийхийг эсэргүүцнэ. Ингэх нь хувийн нууцын эрхэд амархан халддаг.

Далд сурвалжлагын баримтлах гол зарчим. 1. Хууль цаазыг журамлах зарчим. Далд сурвалжлага нь сонин мэдээ сурвалжлагын нэг зүйлийн онцгой

хэлбэр болохын хувьд сэтгүүл зүйн сурвалжлагын нэгэн төрөл бөгөөд өөр онц эрх эдлэх ёсгүй юм. Тиймээс далд сурвалжлага хийхдээ сурвалжлагч хууль цаазыг эрхэмлэхийг чухалчилж, хэдийгээр сурвалжлагын зорилт хууль зөрчигчдийг илчлэх зорилготой байсан ч сурвалжлагын арга хэлбэр хийгээд бүхий л явцаа цөм хууль ёсны байлгах хэрэгтэй. Жишээ нь: "Өвөр Монголын амьдрал гарагын сонин"-ы 2006 оны 12-р сарын 5-ны дугаарын "Их мөрдөл" тусгай нүүрт хэвлэсэн "Хуурмаг үнэмлэл — хотын хижиг" нэртэй мэдээлэлд сурвалжлагч зөвхөн худал үнэмлэл хийх шалтгаар худал үнэмлэл хийдэг хүнтэй уулзаж байдлыг ойлгосноос биш, жинхэнэ зоос гарган худал үнэмлэл хийлгэсэнгүй байна. Хэрэв сурвалжлагч жинхэнэ худал үнэмлэл хийлгэсэн бол тус сурвалжлагч нь мөн ч хууль бус ажиллагаанд оролцсон этгээд болох юм.

2. Ёс зүйг зөрчихгүй байх зарчим. Зарим далд сурвалжлагын арга нь хууль зөрчөөгүй, мөн хүний эрхэнд халдаагүй ч энгийн ёс зүйн зарчмыг зөрчихөөр байвал сурвалжлагч энэ аргыг хэрэглэхгүй байх ёстой. Сурвалжлагч төв голч бөгөөд бусад үнэнийг ч баримтлах хэрэгтэй.

Далд сурвалжлага дахь сурвалжлагчийн шинж чанар. Далд сурвалжлагад сурвалжлагч маш чухал үйлдэл үзүүлж байгаа тул сурвалжлагчийн шинж чанар хийгээд боловсрол нь бүхий л сурвалжлагад туйлын чухал байр эзэлдэг. Өөрөөр хэлбэл, далд сурвалжлагын амжилт олох эсэх нь сурвалжлагчийн шинж чанараас ихээхэн шалтгаалдаг. Тиймээс далд сурвалжлага хийдэг

сурвалжлагч нь энгийн сурвалжлагчид байвал зохих шинж чанараас гадна бас зохих талын тусгай шинж чанарыг бүрдүүлэх ёстой юм.

— Зоригтой, бас нямбай байх. Далд сурвалжлага нь нийгэм дэх элдэв будлиантай байдалд янз бүрийн хүнтэй уулзаж, сурвалжлага хийх учраас маш зоригтой, бас дээд зэргийн нямбай байхыг чухалчилдаг.

— Авхаалж самбаатай, хурц сэргэлэн байх. Далд сурвалжлагад сурвалжлагч өөр нэгэн нэр дүрээр, өөрийн гэсэн тодорхой зорилготой оролцох тул янз бүрийн саад бэрхшээл, заримдаа аюул түгшүүрт ч тулгарах учир нөхцөл байдлыг цаг тухайд нь шинжилж мэдэх хурц мэдрэмж, авхаалж самбаатай байх хэрэгтэй. Ингэвэл тухайн нөхцөл байдалд зөв оновчтой шийдвэр гарган, олох гэсэн баримт мэдээллээ олж чадах юм.

— Мэргэжлийн ёс зүйн хувьд сайн байх. Далд сурвалжлага ихэнх тохиолдолд нийгэмд хор хөнөөл үзүүлсэн, хээл хахууль авсан, эсвэл олон нийтийг хуурч мэхэлсэн хувь хүн буюу зохион байгуулалттай гэмт хэргийг сурвалжлан илчилдэг тул тэд сурвалжлагчийг зоос мөнгөөр болон бусад элдэв аргаар өөртөө татахыг хичээдэг. Тиймээс сурвалжлагч тухайн ажлын ёс зүйн хувьд сайн бөгөөд олон түмэнд зүтгэх дайчин зоригтой байх хэрэгтэй.

— Холбогдох хууль эрх зүйн мэдлэг боловсрол өндөр байх хэрэгтэй. Сурвалжлагч хууль зүйн энгийн мэдлэгийг маш сайн эзэмшихийн зэрэгцээ далд сурвалжлагатай холбоотой аливаа хууль тогтоомж, онцгойлон гэрч баримтын тухай хууль эрхийн актуудыг илүү сайн

ойлгож мэдсэн байх шаардлагатай. Энэ нь далд сурвалжлагыг хууль ёсны болгож, сүүлд гарах янз бүрийн маргаан, сөрөг үр дагавараас баталгаатай хамгаалагдах болно.

Одоогийн далд сурвалжлагад оршиж буй зарим дутагдал, анхаарах асуудал.

Нэгдүгээрт, “хэмжээ”-г зохистой атгах асуудал. Далд сурвалжлага нь олон нийтийн эрх ашгийг хамгаалах, нийгмийн хууль бус худал хуурмаг ажиллагааг илчлэх хамгийн чухал арга барил болж байгаа юм. Иймэрхүү чухал арга барил байгаа учраас нийгмийн гүнд нь нуугдаж байгаа хор арилжаалдаг бүлгэм, хуурамч архины үйлдвэр, бохир тосны үүр, хуурамч эм, бараа таваар, бохир хөвөн, хольцтой сүү, ус тарьсан мах, үхсэн гахайн мах, иргэдийг ямар ч үндэслэлгүй торгох, хээл хахууль авах, эрх мэдэл, албан тушаалаа хэтрүүлэн ашиглах зэрэг нийгмийн олон арван муу муухай хууль бус үйл ажиллагааг хойно хойноос нь илчлэн гаргаж, тэднийг арилгахад чухал нөлөө үзүүлсэн билээ. Энэ нь нэг хэсэг сурвалжлагч далд сурвалжлагыг хэтэрхий “шүтэх” буюу олон нийтэд улам сайн “үйлчлэх”-ийг хүсч, зарим хэрэглэх шаардлагагүй газар ч далд сурвалжлагыг хэрэглэх, эсвэл хэмжээнээс нь хэтэртэл хэрэглэх үзэгдэл газар авч, олон нийтэд үйлчилж чадахгүй мөртлөө эсрэг үйлдэл үзүүлэх явдал гарчээ. Жишээ нь: “Ян Чэнь хотын оройн сонин”-ы нэг сурвалжлагч Шанхайн амрыг хамгаалах цагдаагийн ажлаа хэр зэрэг биелүүлж байгааг шалгах зорилгоор эд юмаа булаалгасан гадаадын жуулчны дүрд тоглож, шуурхай албыг дуудаж,

цагдаагийн дөрвөн тэргийг мэхлэн авчирсан бол Шэнь Янын "Цаг үеийн аж ахуйн сонин"-ы сурвалжлагч мөрийтэй тоглоомын газарт далд сурвалжлага хийх явцад өөрөө мөрийтэй тоглосон байна. Эдгээр сурвалжлагын зорилт нь хэдийгээр олон нийтийн эрх ашгийг эрхэмлэх шинжтэй боловч, сурвалжлага хийх явцад "хэм хэмжээ"-гээ баримталж чадаагүйгээс болж, сурвалжлага нь санаснаас эрс өөр үр дүн авчирсан байна. Иймээс

далд сурвалжлагыг зүй зохистой хийхийн зэрэгцээ мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг дээд зэргээр баримтлах хэрэгтэй.

Хоёрдугаарт, далд сурвалжлага нь зарим муу санаат сурвалжлагч буюу сонин мэдээний ажилтнуудад ашиглагдаж байгаа асуудал юм. Өөрөөр хэлбэл,

далд сурвалжлага нь ил сурвалжлагаар илрүүлж чадахааргүй үнэн бодитой баримт мэдээллийг олж чаддагаараа хууль зөрчигчдийн "сүүл"-ийг барих сайн арга болжээ. Далд сурвалжлага нь хэдийгээр олон нийтийн эрх ашгийг хамгаалж, хууль зөрчигчдийг илрүүлэх зорилготой боловч, зарим тохиолдолд тухайн ажлын ёс суртахуунгүй, хүн чанаргүй сурвалжлагчийн гарт орсноор өнгө төрх нь танигдахааргүй өөрчлөгдсөн явдал цөөнгүй юм. Тэд далд

сурвалжлагаар дамжин хууль зөрчигчдийн "бузар" гэрч баримтыг эзмшсэний дараа дахин мэдээллийн ноорог буюу дүрс бичлэг үйлдэж, шууд мэдээлэх биш, харин урьдаар хууль зөрчигчдэд үзүүлж, тэдний сурвалжлагчид өгөх зоосны тоо хэмжээ, бэлгийн өртгөөр нь мэдээллээ дахин засах, мэдээлэх эсэхээ тогтоодог байна. Энэ бол одоогийн далд сурвалжлагыг хэрэглэж байгаа, мөн сурвалжлагчийн ажлын ёс зүйд оршиж байгаа хамгийн ноцтой, нийгэмд хамгийн хортой асуудал болоод байна. Тиймээс эл мэдээллийн хэрэгслүүд өөрийн яриа хэлэлцээний хяналтыг улам сайжруулж, сурвалжлагч хийгээд аливаа сонин мэдээний ажилтнуудад тухайн ажлын ёс зүйн талаар тодорхой мэдлэг эзэмшүүлэх нь тулгамдсан асуудлын нэг мөн.

«

Далд сурвалжлага нь ил сурвалжлагаар илрүүлж чадахааргүй үнэн бодитой баримт мэдээллийг олж чаддагаараа хууль зөрчигчдийн "сүүл"-ийг барих сайн арга болжээ. Далд сурвалжлага нь хэдийгээр олон нийтийн эрх ашгийг хамгаалах зорилготой боловч, зарим тохиолдолд тухайн ажлын ёс суртахуунгүй, хүн чанаргүй сурвалжлагчийн гарт орсноор өнгө төрх нь танигдахааргүй өөрчлөгдсөн явдал цөөнгүй юм.

»

Гуравдугаарт, далд сурвалжлагыг заавал илчлэл шүүмжлэлийн мэдээлэлд л хэрэглэх биш, зарим эерэг, гэрэл гэгээтэй мэдээлэлд ч бодитойгоор хэрэглэж болно. Хятадын одоогийн байдлаас үзэхэд мэдээллийн хэрэгсэл нь далд сурвалжлагыг ихэнх тохиолдолд цөм илчлэл шүүмжлэлийн шинж бүхий мэдээлэлд хэрэглэж, эерэг талын мэдээлэлд туйлын бага хэрэглэж буй. Далд сурвалжлагаар дамжин шүүмжлэл

хийхийн адил, далд сурвалжлагын онцгой шинж чанарыг ашиглаж тэргүүний хувь хүн буюу нэгжийн сайн сайхан үйл ажиллагааг хамгийн үнэн, хамгийн амьдлаг, хамгийн үнэн бодитойгоор илрүүлэх нь чухал бөгөөд ийм материалын нийгэмд үзүүлэх нөлөө нь асар их юм. Жишээлбэл, нэг сурвалжлагч Жий Наны зам харилцааны цагдаагийн ажилдаа хянамгай, хариуцлагатай байгааг мэдээлэхдээ даруй далд сурвалжлагын аргаар зам харилцааны цагдааг бүтэн нэг өдөр даган сурвалжилж, эцэстээ хамгийн үнэн бодитой, амьд жишээ баримтаар баян мэдээллээр тэдний үйл ажиллагааг ямар ч дэл сул үг нэмэлгүйгээр үнэн мөнөөр нь нийтэлж, олон нийтийг итгүүлэн үнэмшүүлж, талархлыг хүлээсэн байна. Далд сурвалжлагыг ийнхүү эерэг мэдээлэлд хэрэглэвэл, мэдээллийн үнэн бодит чанар, итгүүлэн үнэмшүүлэх чанарыг дээшлүүлэхээр барахгүйн зэрэгцээ хэтрүүлэн мэдээлэх үзэгдлээс зохих хэмжээгээр сэргийлж болох юм.

Дөрөвдүгээрт, Монгол мэдээллийн хэрэгсэл ч бодит байдалд тохируулан далд сурвалжлагыг зүй зохистой, оновчтой ашиглавал зохино. Одоогийн байдлаас үзвэл, манай монгол мэдээллийн хэрэгсэл нь далд сурвалжлагыг ашиглах талаар нэлээд учир дутагдалтай бөгөөд нэгмөсөн гадуурчлах буюу өнгөн тал дээрээ бага сага хэрэглэхийг чухалчилж, далд сурвалжлагыг ашиглан хүчтэй нөлөө үзүүлэхээр мэдээ материал бэлтгэж байгаа нь туйлын цөөн байна. Дээр дурдсанчлан далд сурвалжлага нь одоогийн яриа хэлэлцээнийн хяналт тавих хамгийн

чухал арга барил болохоор зарим тохиолдолд хэрэглэхгүй байхын аргагүй арга барил мөн юм. Тэгэхлээр манай монгол мэдээллийн хэрэгсэл ч бодит байдлаасаа үүсч, “хонжоод шунаж малын зовлого борлуулах нь жигшилтэй, хямдад дурлаж өвчин эмгэг олохыг хичээгүүштэй - Шилийн хотын хууль бусаар малын зовлого арилжаалж байгаа үзэгдэлд хийсэн байцаалт” (“Өвөр Монголын өдрийн сонин”-ы монгол хэвлэлийн 2007 оны 4-р сарын 13-ны “Нийгмийн сонин мэдээ” тусгай нүүр) гэх мэтийн үнэн бодитой, уншууртай, хандлагат хүчтэй мөртлөө гүнчтэй мэдээлэл илүүхэн нийтлэх нь чухал юм.

Ишлэл

¹ 1993. Сонин мэдээллийн бүрэн толь (Ган Ши Фэн эрхлэн найруулсан). Хэ Нань. Ардын хэвлэлийн хороо (хятад хэл дээр).

² Ж а н Ш а о К э. 2006. Далд сурвалжлагад хийсэн байцаалт (хятад хэл дээр). МХИС-ийн хэвлэлийн хороо, 3 дахь тал.

³ З у л ь к а ф и л ь М., Ч о й с а м б а Ч. Сэтгүүл зүйн түүх. УБ., 2005, 198 дахь тал.

⁴ Л ү ө Х а н Ч э н ь. 2005. Далд сурвалжлагын эрх зүйн асуудлын тухай бодол (хятад хэл дээр). Дунд улсын аж ахуйн хэвлэлийн хороо, 40 дэх тал.

⁵ Г ү ө Ж е н ь. “Халуун цэгээс хийсэн ярилцлага”-ын тухай // <http://academic.media-china.net>

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. 2003. Сонин мэдээ сурвалжлан бичих зүй (Бүрээчин Дархан эрхлэн найруулав). ӨМИС-ийн хэвлэлийн хороо.

2. 暗访调查实务》张少科著 中国传媒大学出版社 2006年

3. 行走在火上一急性采访的法律思考》骆汉成著 中国经济出版社 2005年

4. 新闻采访方法论》艾丰著人民日报出版社 2004年

5. 民法》王利明主编 中国人民大学出版社 2003年
6. 新闻舆论研究》丁柏铨主编 新华出版社 2002年
7. 甘惜分主编《新闻学大词典》河南人民出版社 1993年
8. 暗访调查实务》张少科著 中国传媒大学出版社 2006年 3页
9. 行走在火上一急性采访的法律思考》骆汉成著 中国经济出版社 2005年 40页
10. 关于《焦点访谈》的焦点访谈》郭镇之著 <http://academic.mediachina.net>

Резюме

В данной статье автор уделяет внимание проблемам скрытого репортажа, опираясь на газетные публикации последних лет КНР и Внутренней Монголии. Хотя данный метод

внедрил в практику ещё в начале XX века, он почти вышел из употребления после распада Маньчжурской империи и возникновения Китайской республики.

В последние годы снова наметился интерес к скрытому репортажу, который получил широкое распространение особенно в китайской прессе. Однако наметились две противоположные тенденции: игнорирование скрытого репортажа, когда нет другой возможности разоблачить общественно вредные явления и недосмотров, а также высокая частота использования этого метода в тех случаях, когда нет особой надобности, что повлекло за собой обращение в суд уязвлённых людей.